



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 04

Эрлэнэт

Орон нутгийн тусгай хамгаалалтад  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2"к" заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит III Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баян-Өндөр, Жаргалант сумын Хуурай ам, Хөөврийн хөндийн газар бүхий 2173 га, Жаргалант сумын Хөндлөн намгийн газар бүхий 6781 га газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсугай.
2. Орон нутгийн хамгаалалтад авсан дээрх газруудын хилийн заагийг хавсралтын ёсоор баталсугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 104 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.



ДАРГА *[Signature]* Д.ПҮРЭВЛХАГВА